



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
БНДИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/34

Ө.тэй

Журам батлах тухай


Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 51.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 2023 оны 301 дугаар тогтоолын хавсралт, байгууллагын дотоод журмын 8.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын ажилтан, албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмын дагуу ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг холбогдох журам, зааврын дагуу заасан хугацаанд гаргаж, нэгжийн даргад тайлагнахыг ажилтан, албан хаагчдад, хүлээн авсан тайланг дүгнэж, байгууллагын даргад танилцуулан баталгаажуулахыг нэгжийн дарга нарт үүрэг болгосугай. .

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн /М.Еркебулан/-д даалгасугай.

ДАРГА  Х.ХАЙНАР



Баян-Өлгий аймгийн Биеийн тамир, спортын газрын  
даргын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн  
.../24 тоот тушаалын хавсралт



## УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг зүйл

1.1. Төрийн албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 51.1.4-т заасан мөнгөн урамшууллыг олгоход энэ журмыг мөрдөнө.

1.2. Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн энэхүү журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид урамшуулал олгоно.

### Хоёр. Төрийн албан хаагчид ажлын үр дүнгээр тооцон олгох мөнгөн урамшуулал

2.1. Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.

2.2. Энэхүү журмын 2.1-д заасан нөхцлийг хангасан төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг энэ журмын 1.2-т заасан тухайн төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтан гаргана.

2.3. Төрийн жинхэнэ албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход Засгийн газраас баталсан төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам / Засгийн газрын 2023 оны 301 дугаар тогтоол /-д заасан нөхцөл, шалгуурыг баримтална.

2.4. Энэ журмын 2.3-т зааснаас бусад төрийн албан хаагчид / гэрээт ажилтан хамаарна / үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүн / 2.13-д заасан шалгуур үзүүлэлтийн дагуу бичсэн тайлан /-г үндэслэн олгоно.

2.5. Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй, шинээр ажилд ороод туршилтын хугацаанд ажиллаж буй ажилтан, түр томилогдсон ажилтан, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.

2.6. Ажилтан, албан хаагчийн ажлын үр дүн, гүйцэтгэлийг “бүрэн хангалттай”, “хангалттай”, “хангалтгүй” гэж үнэлж, улирал бүр дүгнэнэ.

2.7. Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараахь хувь хэмжээгээр улирал бүр мөнгөн урамшуулал тооцно:

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Албан тушаалын үндсэн цалингаас урамшил тооцох хувь (улиралд)
90-100	Бүрэн хангалттай	25-40 хувь
71-89	Хангалттай	10-24 хүртэл хувь
0-70	Хангалтгүй	0 хувь

2.8. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлт 71-ээс доош хувьтай байгаа тохиолдолд тухайн албан хаагчид улирлын урамшуулал олгохгүй.

2.9. Тус байгууллага нь ажилтан, албан хаагчид мөнгөн урамшуулал олгохдоо энэ журмын 2.4, 2.5-д заасны дагуу ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэж, энэ журмын 2.14-т заасан шийдвэрийг үндэслэн олгоно.

2.10. Байгууллагын нэгжийн даргаас гаргасан дүгнэлтийг үндэслэн ажилтан, албан хаагчдад мөнгөн урамшил олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана.


2.11. Байгууллагын дарга нь төрийн жинхэнэ албан хаагч нар болон нягтлан бодогчийн улирлын ажлыг дүгнэж, мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг гаргана.

2.12. Мөнгөн урамшууллыг дараа улирлын эхний сарын цалинтай хамт олгоно.

2.13. Байгууллагын даргын ажлын үр дүнг аймгийн ЗДТГ болон тухайн албан тушаалтныг томилсон эрх бүхий албан тушаалтан дүгнэж, шийдвэр гаргана.

2.14. Энэ журмын 2.3-т зааснаас бусад төрийн албан хаагчид, гэрээт ажилтны улирлын тайлан гаргах хүснэгт:

2.14. Энэ журмын 2.3-т зааснаас бусад төрийн албан хаагчид, гэрээт ажилтны улирлын тайлан гаргах хүснэгт  
 ... ХЭЛТСИЙН ... АЛБАН ТУШААЛТАЙ ...-НЫ ... ОНЫ ... УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН



№	Хийж, гүйцэтгэсэн үйл ажиллагаа	Өөрийн үнэлгээ	Хэлтсийн даргын үнэлгээ	Хэлтсийн даргын үнэлгээний тайлбар
1. Ажлын тайлан буюу ажлын байрны тодорхойлолтод/төлөвлөгөөнд заасан үүргийн биелэлт - 50 оноо/				
1				
2				
...				
2. Ажлын идэвхи, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал – 10 оноо/				
1				
...				
3. Тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал – 10 оноо/				
1				
...				
4. Ажлын цаг ашиглалт – 10 оноо/				
1				
5. Албан бичгийг хугацаанд барагдуулсан, тайланг хугацаанд хүргүүлсэн байдал – 10 оноо/				
1				
6. Ажлын хариуцлага, удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт – 10 оноо/				
1				

... ХЭЛТСИЙН ... ОНЫ ...-Р УЛИРЛЫН АЖЛЫН ДҮГНЭЛТ

№	Шалгуур	Ажлын тайлан буюу ажлын байрны тодорхойлолт од заасан үүргийн биелэлт - 50 оноо	Ажлын идэвхи, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал - 10 оноо	Тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал - 10 оноо	Ажлын цаг ашиглалт - 10 оноо	Албан бичгийг хугацаанд барагдуулсан, тайланг хугацаанд хүргүүлсэн байдал - 10 оноо	Ажлын хариуцлага, удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт - 10 оноо	Нийт - 100 оноо	Урамшууллын хувь (100 оноо = 60%)	БТСТ-ын даргын баталгаажуулалт
	Ажилтны нэрс									
1										
2										
3										
4										
5										
6										
7										
8										
...										

Огноо .....

/...../

Ажил дүгнэсэн: Хэлтсийн дарга

Огноо .....

/.../

Баталгаажуулсан: дарга